



ЧИНГЭЛТЭЙ ДУУРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот


Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэсвгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороодын ажиллах журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Хорооны ажлыг батлагдсан журмын дагуу зохион байгуулж, үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд идэвх санаачлагатай ажиллахыг Хурлын хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 11 дугаар сарын
25-ны өдрийн 63 дугаар тогтоолын хавсралт



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХОРООДЫН АЖИЛЛАХ ЖУРАМ**
/Шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хороо нь /цаашид хороо гэх/ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хурлын байгууллагын үйл ажиллагааг тогтмолжуулах, Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, дүүргийн эдийн засаг, нийгмийн амьдралын олон талт асуудлуудыг шийдвэрлэх, Хурлын тасралтгүй байнгын үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий Хурлын бүтцийн нэгж мөн.

1.2. Хороо нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

1.3. Хороо нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод нээлттэй байх, бусдын нөлөөнд үл автах, Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх зарчмыг баримтална.

1.4. Хурлаас цаг үеийн асуудлыг судлах, санал дүгнэлт боловсруулах, хянан шалгах үүрэг бүхий түр хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно. Түр хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тодорхой чиглэлээр мэргэжлийн байгууллагын туслалцаа авах, мэргэжилтэн, зөвлөх, асуудал хариуцсан ажилтан нарыг оруулж болох бөгөөд тэдгээрийн ажлын үр дүнг харьяалах хорооны хурлаар хэлэлцүүлж шаардлагатай тохиолдолд Хурлын хуралдаанд оруулна.

1.5. Хороог 5-7 Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр Хурлын бүрэн эрхийн хугацаагаар байгуулах бөгөөд хороодын тоо, эрхлэх асуудал, үйл ажиллагааны журмыг тэдгээрийн саналыг үндэслэн хэлэлцэн шийдвэрлэнэ. Хорооны даргыг тухайн хорооны Төлөөлөгчдийн дотроос сонгоно.

1.6. Хорооны гишүүн нь хууль тогтоомж, энэхүү журамд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, ажиллах нөхцөл баталгаагаар хангагдана.

Хоёр. Хорооны ажлын зохион байгуулалт

2.1. Хорооны үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь Хуралдаан байна.

2.2. Хороо нь хариуцсан ажлын чиглэлээр асуудлыг судалж, боловсруулах, шалгаж танилцах, дүгнэлт санал гаргах, ээлжит болон ээлжит бус хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал боловсруулж хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг сурталчилах, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг дүгнэх зэргээр ажиллана.

2.3. Хороо нь хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх ба хорооны дарга, гишүүд нь хуралдаанд таслах эрхтэй оролцено.

2.4. Хорооны нарийн бичгийн дарга нь Хурлын Ажлын албаны ажилтан байх бөгөөд хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, хорооны дарга, гишүүдтэй байнгын холбоотой ажиллана.

2.5. Хорооны нарийн бичгийн дарга нь хорооны дарга, гишүүдийг мэдээ, мэдээллээр хангах, хорооны хурлыг зохион байгуулах бэлтгэлийг хангах, хуралд оролцогчдод зар хүргэх, хурлын байр, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтлөх, албажуулах, хурлын хорооноос гарах шийдвэрийн төсөл боловсруулах зэрэг ажлыг зохион байгуулна.

2.6. Төлөөлөгч нь 2-оос илүүгүй хороонд харьялагдах ба бусад хороодын хуралдаанд оролцож, санал гаргах, уг хэлэх эрхтэй бөгөөд зөвхөн өөрийн харьялагдах хорооны хуралд таслах эрхтэйгээр оролцено.

2.7. Хорооны хурал нь тухайн хорооны Төлөөлөгчийн олонх нь хүрэлцэн ирсэнээр хүчин төгөлдөр болох бөгөөд асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.8. Хороо нь Хурлын дарга, Тэргүүлэгчдээс баталсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулна.

2.9. Хорооны хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа нэгдсэн хуралдаан, нам, эвслийн бүлэг, бусад хороодын хурлын товтой давхацуулалгүйгээр зохион байгуулна.

2.10. Хороо нь Хурлын хуралдаанаар хэлэлцэх аливаа асуудал, шийдвэрийн төсөлд иргэдээс санал авах зорилгоор уулзалт, хэлэлцүүлэг, нээлттэй өдөрлөг зэрэг бусад үйл ажиллагааг зохион байгуулж болно.

2.11. Хороо нь зөвхөн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд хэлэлцсэн асуудлаараа санал дүгнэлт, зөвлөмж гарган Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

2.12. Хурлын дарга хороодоос ирүүлсэн санал, дүгнэлтийг Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх ба нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхээр өргөн барьсан

шийдвэрийн төсөлд хороодын санал дүгнэлтийг тусгуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсний дараа төслийн эцсийн найруулгыг хийж, нэгдсэн хуралдаанд оруулна.

2.13. Хороо нь жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан Хурлын Тэргүүлэгчдээр батлуулах бөгөөд хийсэн ажлаа Тэргүүлэгчдийн хуралдаанд хагас жил тутамд мэдээлж байна.

2.14. Хороо хэлэлцэн асуудлаараа санал, дүгнэлт, зөвлөмж гаргах бөгөөд түүнийг тухайн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхиын саналаар батлана.

2.15. Хорооны шийдвэрт хорооны дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

Гурав. Хорооны чиг үүрэг, баталгаа

3.1. Хороо нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар зохих мэдээ, тооцоо, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, үйл ажиллагааг нь шалгах, шаардлага тавих, биелэлтийг хангулж ажиллана. Шаардлагатай тохиолдолд Тэргүүлэгчдийн шийдвэрээр ажлын хэсэг томилон ажиллуулж болно.

3.2. Хороо нь ажлын шаардлагаар холбогдох байгууллага, мэргэжилтэн, эрдэмтэн, иргэнийг үйл ажиллагаандаа татан оролцуулах замаар оновчтой зөв шийдвэр гаргахад ажлаа чиглүүлж ажиллана.

3.3. Эрхлэх асуудлын хүрээнд олон нийтийг хамарсан хууль тогтоомж, хурлын шийдвэрийг сурталчилах ажлыг зохион байгуулж болно.

3.4. Хороо нь хяналт шалгалт хийсэн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, үр дүнтэй үйл ажиллагааг дэмжих, илэрсэн зөрчил дутагдалыг тогтоох, түүнийг арилгуулах, давтан гаргуулахгүй байх арга хэмжээ авахуулах, шаардлагатай бол хариуцлага тооцуулах тухай асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд саналаа тавьж шийдвэрлүүлнэ.

3.5. Хороо нь хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

3.6. Байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан нь хороодын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх ба хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдалыг арилгах, хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох, холбогдох арга хэмжээ авах талаар хорооноос тавьсан шаардлагыг биелүүлж, үр дүнг тогтоосон хугацаанд албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.

3.7. Хороодын үйл ажиллагааны зардлыг хурлын жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх бөгөөд хорооны хэвийн ажиллах нөхцөлийг Хурлын Ажлын алба хангаж ажиллана.

3.8. Хорооны дарга, гишүүд нь ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, өөрийн бүрэн эрхийн хүрээнд олж авсан Төрийн байгууллага, хувь хүний нууцыг чанд хадгална.

Дөрөв. Хорооны даргын чиг үүрэг

4.1. Хорооны дарга нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1. Тухайн хорооны жил, улирлын ажлын төлөвлөгөөг хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавих

4.1.2. Хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

4.1.3. Хорооны гишүүдэд үүрэг чиглэл өгөх

4.1.4. Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах

4.1.5. Хорооны нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцах

4.2. Эрхлэх асуудлын хүрээнд холбогдох газар, хэлтэс, албаны үйл ажиллагаатай танилцах, мэдээ, мэдээлэл гаргуулж авах, шаардлагатай гэж үзвэл ИТХ-ын Тэргүүлэгчдэд асуудал оруулж шийдвэрлүүлэх

4.3. Хорооны дарга нь тухайн хорооны ажлыг дүүргийн Хурлын өмнө хариуцана.

Тав. Хорооны эрхлэх асуудал, үйл ажиллагааны чиглэл

5.1. Хороо нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

5.1.1. Эрх зүй, нутгийн удирдлагын хороо

5.1.2. Эдийн засаг, төсвийн хороо

5.1.3. Төсвийн зарцуулалтын хяналтын хороо

5.1.4. Ногоон хөгжил, газрын харилцааны хороо

5.1.5. Хот байгуулалт, үйлдвэрлэл, үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо

5.1.6. Нийгмийн хөгжлийн хороо

5.1.7. Ёс зүй, өргөдлийн хороо

5.2. Хороод нь дараах эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

5.2.1. Эрх зүй, Нутгийн удирдлагын хороо

- А. Эрх зүйн бодлого, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн хэрэгжилт, хяналт шалгалт
- Б. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Тамгын газар, хороо, харьяа хэлтэс, албадын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа
- В. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа
- Г. Гамшигаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа
- Д. Улс төрийн нам, сүм хийд шашны байгуулагатай харилцах асуудал
- Е. Хөрөнгө оролгын мэдүүлэг гаргах, хадгалах асуудал
- Ё. Дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа бодлого, үйл ажиллагаа

5.2.2. Эдийн засаг, төсвийн хороо

- А. Дүүргийн төсөв, санхүү, татварын бодлого, үйл ажиллагаа
- Б. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
- В. Орон нутийн хөгжлийн сан
- Г. Татварын орлогын бүрдүүлэлт, эх үүсгэвэрийг нэмэгдүүлэх боломж, энэ талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт
- Д. Дүүргийн хөгжлийн хандлагыг тодорхойлох үндсэн чиглэл, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт
- Е. Гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусlamжийн бодлого
- Ё. Орон нутгийн өмч, газрын харилцааны бодлого, удирдлага, зохицуулалт
- Ж. Орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт

5.2.3. Төсвийн зарцуулалтын хяналтын хороо

- А. Дүүргийн төсвийн зарцуулалт, түүний гүйцэтгэл
- Б. Дүүргийн төсөв, санхүү, татварын бодлого, үйл ажиллагаа
- В. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл
- Г. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт
- Д. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эзэмжилт, ашиглалт, захиран зарцуулалт
- Е. Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусlamжийн үр ашиг, үр нөлөө
- Ё. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн
- Ж. Дотоод аудитын үйл ажиллагаа

5.2.4. Ногоон хөгжил, газрын харилцааны хороо

- А. Байгаль орчин, экологийн асуудал, хууль тогтоомжийн хэрэгжилт
- Б. Орон нутгийн тусгай хамгаалалтай газар
- В. Ногоон бүсийн газар нутгийг ашиглах, ээмшүүлэх, хамгаалах асуудал
- Г. Байгаль орчны хяналт
- Д. Агаар, хөрсний бохирдол, тохижилт орчны цэвэрлэгээ
- Е. Усны бодлого, гол мөрөн, булаг шандны хамгаалалтын дэглэм
- Ё. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт
- Ж. Хог хаягдлын менежмент
- З. Газрын тухай хуулийн хэрэгжилт
- И. Газар ашиглах, ээмшүүлэх, өмчлөлийн тухай

5.2.5. Хот байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо

- А. Барилга хот байгуулалт
- Б. Дэд бүтэц, зам, талбайн тохижилт
- В. Хүнсний болон хөнгөн үйлдвэрийн бодлого
- Г. Хүсний бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал
- Д. Гэр хорооллын хөгжлийн бодлого, төсөл хөтөлбөр
- Е. Хороо хөгжүүлэх бодлоготой холбоотойгоор хэрэгжих гадаад орны болон олон улсын байгууллагын зээл тусlamжийн асуудал
- Ё. Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого
- Ж. Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бодлого
- З. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого
- И. Эрчим хүч, гэрэлтүүлэг
- Й. Зам, нийтийн тээвэр, шуудан, харилцаа холбоо
- К. Орон сууц, нийтийн аж ахуй
- Л. Тохижилт, цэвэрлэгээ

5.2.6. Нийгмийн хөгжлийн хороо

- А. Хүн амын эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спорт
- Б. Боловсрол
- В. Соёл урлаг
- Г. Шинжлэх ухаан
- Д. Хүн ам зүйн бодлого, зохицуулалт
- Е. Нийгмийн хамгааллын бодлого, үйл ажиллагаа
- Ё. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа
- Ж. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харицаа, хөдөлмөр хамгаалал
- З. Ахмадын бодлого, дүүргийн ахмадын хорооны үйл ажиллагаа
- И. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн бодлого, үйл ажиллагаа

5.2.7. Ёс зүй, өргөдлийн хороо

- А. Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хяналт

- Б. Иргэний танхимын үйл ажиллагаа
- В. Санал асуулга, олон нийтийн санаа бодлын тандалт судалгаа
- Г. Хурлын хуралдааны дэгийн биелэлт
- Д.Хурлын Төлөөлөгч хөрөнгө орлогын мэдлүүлэгээ хугацаа хоцроосон эсвэл мэдүүлээгүй бол холбогдох эрх бүхий байгууллагын шаардлагаар
- Е. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих
- Ё. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих

5.3. Хороодын үйл ажиллагааны чиглэл, эрхлэх асуудлын хүрээг хурал өөрөө тогтооно.